



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 1/57

Алтай хут

**Аймгийн Боловсрол, шинжлэх
ухааны газрын бүтэц орон тоог батлах
тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469, 417 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлах тухай" А/125 дугаар тушаал, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнжаргал)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/273 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны ...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
 захирамжийн хавсралт

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
 БҮТЭЦ, ОРОН ТОО**

№	Албаны нэр	Боловсрол, шинжлэх ухааны газар	Орон тоо
1	Сургалт, судалгаа, аргазүйн алба	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1
2		Сургалтын бодлогын хэрэгжилт, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, боловсролын баримт олгох асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3		Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
4		Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
5		Монгол хэл, бичиг, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
6		Математик, физик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
7		Хими, биологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
8		Түүх, нийгмийн ухаан, газарзүйн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
9		Гадаад хэлний боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
10		Хөгжим, гоо зүй, насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
11		Дүрслэх урлаг, зураг зүй, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
12		Биеийн тамир, эрүүл мэндийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
13		Боловсролын хяналтын улсын байцаагч	1
14		Бодлого, төлөвлөлт, захиргаа, үйлчилгээний алба	Бодлого, төлөвлөлт, захиргаа, үйлчилгээний албаны дарга
15	Төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн		1
16	Статистик мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн		1
17	Хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн		1
18	Шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалт, багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэн		1
19	Хүүхдийн хөгжил хамгаалал тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн		1
20	Сурах бичиг, сургалтын орчин, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		1
21	Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн		1
22	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн		1
23	Нягтлан бодогч		1
24	Нярав		1
25	Архив, бичиг хэргийн ажилтан		1
Батлагдсан орон тоо			25